



Яруу найрагч Уушийн Батболд Монххайрхан сумын уугуул. Анхны шүлэг нь 1981 онд тэрвөийн пионерийн үнэн сонинд гарч байсан бол одоо “Элгэн талын нутаг”, “Зүрхний анир”, “Намрын цагаан овс, Хязгааргүй хайрла” зэрэг номуудаа уншигчдад оргон барихаар бэлтгэж байна. Амгалан хох уулс, ходоогийн цэнгэг салхины амьсгал дайсан, эгэл болоод сэтгэлд ойрхон торхот энэ найрагч бээр идээшиж дассан буйд ходоогоосоо буйр сэлгэж, саяхнаас аймгийн товд суурьших болжээ. Манай утга зохиолынхны дунд зүй ёсоор хүндлэгддэг тэрбээр тов бараадан ирсэн нь олонд тодий л танил болоогүй түүнийг зохиол бүтээлээ түмэнд хүргэж, нэгэнтээ ил гарч ирэхэд нь тустай болсон мэт.

Найрагч маань саяхан болсон “Ховд 80” яруу найргийн наадамд тэргүүн дэд байр эзэлж, ур цэц нь жигдэрч намуун зоолон аялгуу эгшиглэсэн, бас заримдаа сүрхий зоримог онго аяс цухалзуулсан шүлгүүдээрээ олны сэтгэлийг татаж чадсан юм

Г.Төрмөнх

БИ ХУУЧИН ЭХ ОРОНДОО ХАЙРТАЙ

Шил толины гялбаа сансрыг эзэгнэсэн зуунд ч

Шинжлэх ухааны эрин илүүдсэн хогжлийн давалгаанд ч

Дээлтэй овгодийн минь үлдээж огсон

Дэлхийн хох монголоос оор шинэ эх орон гэж хаана байна вэ

БНМАУ гэж байхдаа Бүтэн байсан элгэн нутаг минь

Бүс чангатай эзэн түмэн нь Бүрэн байсан газар шороо минь

Сарны гэрлийн эртний садан

Салхи тань хүртэл хуучных байсан ч

Сахал буурал хох овгодийн

Үнэр нь хүртэл хуучных байсан ч

Овсний үндэсийг сэрээж эвлэгсэн

Олзийт наран тань хуучных байсан ч

Оноодрийн амьдралыг хотлож ирсэн

Орлог шаштир тань хуучных байсан ч

Ээжийгээс минь илүү настай болохоор нь

Эх орондоо хайртай юмаа би

Тэнгэрийн тамгатай сургаальт ховгүүн

Тэмүүжин Чингис хуучных байсан ч

Хуур татахад уйлж явсан

Хутагт Равжаа хуучных байсан ч

Амарсанаа,Галданбошигт хуучных болохоор

Алунгоо,Овлэн эх хуучных болохоор

Би тэдний тогсголгүй үргэлжлэл тул

Буй биеэрээ хуучин эх орондоо хайртай

Бичсэн шүлэг минь тэнгэрийнх нь хишиг юм чинь

Бид оорсдоо газрынх нь гал юм чинь

Ургасан бие минь моддынх нь үндэс юм чинь

Унах шороо минь алтан дэвсгэр юм чинь

Морин хуурынх нь аялгуу

Моцартын симфоныг даралдаг хуучин эх орноо би

Мохож үзээгвй зүрхэн дээрээ л

Монгол минь гээд ачиж явдаг юм

Би хуучин эх орондоо хайртай

ГИТАРЫН ДУУ

Мянган бээрийн одод

Тэнгэртээ л эрхлүүлсэн тэр шоно

Миний зүрхэнд гитарын дуу

Тэгтлээ л хоногшсон доо

Бодь харцтай хоорхон нүд чинь

Бодол шаглан навчин дээр тусаж

Чангаран уянгалах гитарын эгшигнээс

“Уулзаж амжаагвй ээж минь гэсэн

Учирлэн дуудсан аялгуу урсаж

Уйлж байсныг санаж байна

Тэгэхэд Тэсгэлгвй уяхан миний

Тэрлэгний энгэр нулимстаж

Товчин товчин үрлүүд

Амьдралын гашууныг сануулан

Амтагдаж байсныг мартаагвй

Харин бас

Хангинаж л байдаг гитарын тэр дуунаас

Хайрын зурлага асгарч

Сэтгэлд сэргэлт зарлаж

Онгодыг минь эмээллүүж

Орон зайд намайг давхиулж

Шүүрс алдуулан шүлэг нэрүүлсэн

Гоц нэгэн гитарын дуу

Гарцаагвй ганцхан чинийх л байсныг

Санасаар явна аа найз минь

Санчиг минь онговч мартагвй ээ

АМЬДРАЛ

Бүргэд жингвйдэхэд болжмор атаархана

Бүжин дэгдэхэд мэлхий орилно

Салхи дуулахад үүлс хэрэлдэнэ

Адуу газраар бус тэнгэрийн заадсаар давхина

Аянга тэнгэрээс бус газрын цаваар цахилана

Доромсон улирал гурван зуун жаран тав хоногтойгоо

Дороон доогуур минь шургана

Айсуу яваа бүсгвй хvн шиг гоё

Ангирын дуутай зун цаг ирнэ

Хэрээ бархирч, хохоо донгодох нь хогжим мэт болж

Хэзээ ч үл зогсох нарны ходолгоон үргэлжилнэ